



YAG
УНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга: С.Энхзаяа
Утас: 261663
enkhzayas@audit.gov.mn
Аудитын менежер:
С.Оюунгэрэл
Утас: 260512
oyungerelts@audit.gov.mn
Аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740

Монгол Улсын Үндэсний аудитын газар

Монгол Улс
Чингэлтэй дүүрэг
Бага тойруу
Засгийн газрын IY байр

Цахим хуудас:www.audit.mn

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Хавсралт 4: Жилийн төсвийн гүйцэтгэлийн
нэгтгэсэн тайлан

Оршил

Хөдөлмөрийн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна. Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Сайдын багцын 2013 оны төсөвт зардал 235,156.2 сая төгрөгөөр батлагдсанаас 198,519.1 сая төгрөгийг зарцуулж, 36,637.1 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл **6,618.4** сая, тайлант хугацаанд **343,325.7** сая төгрөгийн орлого орж, урсгал зардал 167,389.2 сая, хөрөнгө оруулалтын зардал 13,005.0 сая, санхүүгийн үйл ажиллагааны зардал 101,879.9 сая, нийт **282,274.1** сая төгрөгийн зарлага гарч, оны эцэст **67,670.0** сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2013 оны Төсвийн тухай хуулиар өөрийн орлогын төлөвлөгөөг 139,900.7 сая төгрөгөөр баталж үйл ажиллагаагаа санхүүжүүлэх эрх олгосноос гүйцэтгэлээр 127,636.4 сая төгрөгийн орлого олж, 91.2 хувийн биелэлттэй гарсан ба орлогын төлөвлөгөө 12,264.3 сая төгрөг буюу 8.8 хувиар тасарсан байна.

Өөрийн орлогын төлөвлөгөөний бүрдүүлэлтийг шалгахад: үндсэн үйл ажиллагааны орлого 14,324.2 сая төгрөгөөр тасарч, үндсэн бус үйл ажиллагааны орлого 2,059.9 сая төгрөгөөр давуулан биелсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө тасарсан гол шалтгаан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр төсөвлөсөн хэмжээнээс 15,427.8 сая, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын төлбөрийн орлого 311.9 сая төгрөгөөр тус тус тасарсан нь нөлөөлжээ.

Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого тасарсан гол шалтгаан нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 60 дугаар тогтоол “Гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай”, 2012 оны 192 дугаар тогтоол “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” тогтоол зэрэг Монгол иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дотооддоо дэмжих Засгийн Газрын бодлоготой холбоотой байна.

Сургалтын төлбөрийн орлого тасарсан шалтгаан нь ЗГ-ын 2013 оны 161 дүгээр тогтоолоор ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиас Өвөрхангай, Сүхбаатар аймгуудын Технологийн сургууль, УБ хотын Барилгын политехник коллежи тус бүр гарч, 2013-2014 оны хичээлийн жилд бакалаврын боловсрол эзэмшихээр суралцаж байсан оюутнууд өөр сургуулиудад шилжин суралцсантай холбоотой байна.

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад Хөдөлмөрийн сайдын төсвийн багцад 2013 онд **13,446.7** сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр **8,349.2** сая төгрөгийн санхүүжилт олгогдож, **5,097.5** сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 195.9 сая төгрөг нь тендерийн хэмнэлт байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 69.1 хувь буюу 5,768.7 сая төгрөг орон нутагт эрх нь шилжсэн бол 30.9 хувь буюу 2,580.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт Хөдөлмөрийн яаманд нээлттэй тендер зарлан хэрэгжсэн байна.

2013 онд Хөдөлмөрийн сайдын төсвийн багцад барилга 4,640.3 сая, их засвар 1,128.4 сая, автомашин 1,101.9 сая, тоног төхөөрөмж 1,232.1 сая, тавилга эд хогшил 246.5 сая, нийт **8,349.2** сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

ТӨХ-ны 2013 оны 220 дугаар тогтоолоор 2013 онд хөрөнгө оруулалтаар бэлтгэх автомашины тоо, худалдан авах автомашины хөдөлгүүрийн багтаамж, үнийн дээд хязгаарыг тогтоож, худалдан авах зөвшөөрөл олгосны дагуу Хөдөлмөрийн яам нээлттэй тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, худалдан авалтыг хийсэн боловч Хөдөлмөрийн төв биржийн 2 ширхэг Toyota Land Cruiser-200 автомашиныг ТӨХ-ны тогтоолд заасан үнийн дээд хязгаар болох 257.0 сая төгрөгөөс 2.1 сая төгрөгөөр илүү үнээр бэлтгэсэн байна.

2012 онд улсын төсөвт хөрөнгө оруулалтаар батлагдсан боловч санхүүжилт хийгдээгүй **3,009.1** сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-д: “төсвийн захирагч нь 43.1.2-т заасан төсвийг дараагийн төсвийн жилийн 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд зарцуулах эрхтэй” гэснийг үндэслэн 2013 онд санхүүжүүлсэн байна.

Хөдөлмөрийн сайдын төсвийн багцад хамрагддаг 84 төсвийн шууд захирагч нараас аудитад 82 нь хамрагдсан ба нийт төсөвт зардлын 1.3 хувь нь аудитад хамрагдаагүй ба 61.4 хувийг Үндэсний аудитын газар, 24.3 хувийг Аймаг, нийслэлийн аудитын газар, 13.0 хувийг Гэрээт хувийн аудитын компаниуд тус тус хамарч санхүүгийн тайланд аудит хийсэн байна.

Аудитад хамрагдсан 82 салбар, нэгжийн 71 нь “Зөрчилгүй”, 7 нь “Хязгаарлалттай” санал, дүгнэлттэй бөгөөд 4 нь сайдын төсвийн багцад түүврээр хамрагдсан болно.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Аудитын явцад дотоод хяналтыг үнэлэхэд: Хөдөлмөрийн тухай хууль, 2013 оны Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжууд болон Засгийн газрын шийдвэр, Сангийн яамнаас гаргасан заавар, журмын хэрэгжилт хангалттай боловч Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хурлаар Хөдөлмөрийн хэлтсүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, ажиллах нөхцөл байдлыг бүрдүүлэх

зорилгоор **3,013.9** сая төгрөгийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөс зарцуулахаар шийдвэрлэсэн нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуультай нийцэхгүй байна.

Аудитаар дээд түвшний хяналтын асуудал хөндөгдсөн бөгөөд тэдгээрийг удирдлагын анхааралд хандуулж байна.

Төсвийн шууд захирагч нарын 2013 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын талаар

Аудитаар нийт 18,399.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 95.3 сая төгрөгийн зөрчилд 19 акт бичигдсэн, 3,643.2 сая төгрөгийн зөрчилд 20 албан шаардлага тавигдсан, 8,293.2 сая төгрөгийн зөрчилд 177 зөвлөмж өгөгдсөн, 6,367.5 сая төгрөгийн 75 алдаанд залруулга хийгдсэн байна.

Аудитаар илэрсэн бүх асуудлыг тус байгууллагын удирдлага болон дотоод аудитын нэгж авч үзэж, судлан шийдвэрлэх шаардлагатай ба аудитын явцад илрүүлсэн алдааг үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрч, залруулга хийгдсэн байна.

2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Тус яамны аппаратад 2013 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас ТӨХ-ны 2013 оны 217 дугаар албан бичгээр нийт **168.7** сая төгрөгийн өртөгтэй 3 ширхэг суудлын автомашиныг балансаас балансад шилжүүлсэн боловч тайлант хугацаанд орлогод аваагүй байна.
Энэ нь УСНББОУС-17, НББ-ийн тухай хуулийн 4.1.1-д: “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх”, НББНХЗЗ-ын “өртөг болон уялдаатай байх зарчим”-уудтай нийцэхгүй байна.
- Яамны харьяа БНСУ дахь нэг цэгийн үйлчилгээний төвийн воны харилцах дансанд 19.3 сая вон буюу 30.9 сая, бэлэн мөнгөний кассын дансанд 5.4 сая вон буюу 7.2 сая, нийт 38.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.
- Яамны харьяа БНСУ дахь нэг цэгийн үйлчилгээний төвийн төсвийн гүйцэтгэл нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу зарим зардал бараа үйлчилгээний зардлын бүлэглэл хооронд зохицуулалт хийгдсэн боловч байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал 2.1 сая, эд хогшлын зардал 0.5 сая, бусад бараа үйлчилгээний зардал 8.9 сая төгрөгөөр тус тус бүлгийн дүнгээр хэтэрсэн байна.
- ХЭДС-гийн нийт төсвийн гүйцэтгэл 79,490.5 сая төгрөгөөс 1,447.4 сая төгрөгийн ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад 76.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- ХЭДС-гийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан заавар журмын дагуу бэлтгэгдээгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д: “Аж ахуйн нэгж, байгууллага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад, төсөвт байгууллага нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн санхүүгийн тайлангаа гаргана” гэсэн заалттай

нийцэхгүй байна. Иймд НББ-ийн тухай хууль болон УСНББОУС-д нийцсэн тайлангийн маягт, заавар журмыг баримтлан ажиллах шаардлагатай байна.

- ЖДҮХС-гийн 2013 оны батлагдсан төсөвт хөрөнгө оруулалтын зардал тусгагдаагүй боловч тухайн сангийн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж 200.0 сая төгрөгийн автомашины зардлыг Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/28 дугаар тушаалын дагуу нэмэлт санхүүжилтээр батлан зарцуулсан ба Үүний дагуу тайлант онд бэлтгэсэн 2 ширхэг автомашины нэг болох 35.0 сая төгрөгийн өртөгтэй KIA OPTIMA 04-20 УНУ автомашин нь тухайн сангийн хөрөнгөд бүртгэлтэй боловч Хөдөлмөрийн яамны үйл ажиллагаанд ашиглагдаж байна.
- ЖДҮХС-гийн төсвөөр батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласантай холбоотой удирдах зөвлөлийн гишүүдийн цалинд 30.6 сая, сайдын зөвлөх болон гэрээт ажилтан 4 хүний цалинд 34.2 сая, нийт **64.8** сая төгрөгийг төсөвт зардлаас хэтрүүлэн олгосон нь ЗГТС-гийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь "энэ хуулийн 6.4-т заасан тусгай сангийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг Засгийн газар тогтоох бөгөөд хөрөнгийг нь захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ЖДҮХС-гийн 2013 оны батлагдсан төсөвт хөрөнгө оруулалтын зардал тусгагдаагүй боловч тухайн сангийн удирдах зөвлөлийн хурлаар 409.9 сая төгрөгийг Хөдөлмөрийн яамны их засварын зардалд зарцуулахаар шийдвэрлэж, Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/28 дугаар тушаалын дагуу нэмэлт санхүүжилтийг баталж, зарцуулсан байна. Энэ нь ЗГТС-гийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Зориулалт бус зарцуулалтын талаар

Хөдөлмөрийн яам нь 2012 оны төсвийн төслөөр санал оруулсан боловч 2013 оны Төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын зардалд батлагдаагүй санхүүжилтийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/23 дугаар тушаалаар "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-гийн 2013 онд батлагдсан төсвөөс шинээр байгуулагдаж буй Хөдөлмөрийн хэлтсүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, ажиллах нөхцөл байдлыг бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын шинж чанартай, тоног төхөөрөмж 850.3 сая, тавилга эд хогшил 735.6 сая, автомашин 1,428.0 сая, нийт **3,013.9** сая төгрөгийг зарцуулжээ.

Үүнээс орон нутгийн хөдөлмөрийн хэлтсүүд тухайн аймгийн худалдан авах ажиллагааны нэгжээр дамжуулан автомашиныг худалдан авсан бол тавилга, тоног төхөөрөмжийг яамнаас өгсөн чиглэлийн дагуу нэр бүхий 2 компаниас шууд худалдан авсан байна.

Дээрх үйл ажиллагаа нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйл 23.3 дахь "ХЭДС-гийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дотоод хяналтын талаар

ХЭДС-гаас хөдөлмөрийн хэлтсүүдэд бэлтгэсэн нийт 3,013.9 сая төгрөгийн хөрөнгийн 1,428.0 сая төгрөгийн автомашиныг худалдан авах ажиллагааг орон нутгийн худалдан авах үйл ажиллагааны газар зохион байгуулсан бол 1,585.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгын худалдан авалтын үйл ажиллагаа, тендер хаана зохион байгуулагдсан нь тодорхойгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Хөдөлмөрийн хэлтсүүдийн худалдан авсан автомашины үнийн судалгааг харьцуулахад 2006 оны Лексус 470 автомашиныг Архангай аймаг 50.0 сая, Баян-Өлгий аймаг 67.4 сая, 2006-2007 оны Старекс автомашиныг Баянхонгор, Булган, Дархан-Уул, Орхон аймгууд 16.0-23.0 сая, 1997 оны Ланд крузер 80 автомашиныг Увс аймаг 39.9 сая, Ховд аймаг 24.0 сая, 2005 оны Ланд крузер 105 автомашиныг Хэнтий аймаг 68.0 сая, 2010 оны оны Ланд крузер 200 автомашиныг Завхан аймаг 68.0 сая төгрөгөөр буюу харилцан адилгүй үнээр худалдан авсан байна.

Аудитаар нийт 18,399.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч байгаа нь дотоод аудит шаардлагын хэмжээнд хүрч ажиллаагүйг харуулж байна. Иймд дотоод аудитын үр нөлөөг дээшлүүлэх зөвлөмж өгөгдсөн.

Төсвийн төлөвлөлтийн талаар

Төсвийн гүйцэтгэлээр ажилгүйдлийн даатгал, бичиг хэрэг, биеийн тамирын уралдаан тэмцээн, тавилга, урсгал засвар, төлбөр хураамж болон бусад зардал, банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж, амь даатгал зэрэг зардлууд 1.0-163.9 сая төгрөгөөр батлагдсан төсөвт зардлаас хэтэрсэн байна.

2013 онд нийт төсвийн гүйцэтгэлээр цалин хөлс, НДШ-ийн зардал 1,655.5 сая, урсгал үйл ажиллагааны зардал 1,925.2 сая, зардлын зүйл тус бүрээр хянах зардал 33,056.9 сая, нийт 36,637.6 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн байна.

Санхүүгийн тайлагналын талаар

Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/218 дугаар тушаалаар баталсан хуваарийн дагуу төвлөрсөн арга хэмжээний зардал буюу сургалт, сурталчилгаа, томилолт, уулзалтын зардалд 1,552.8 сая, үндэсний хөтөлбөрт 365.7 сая, бодлогын баримт бичиг, хөтөлбөр төсөл, арга хэмжээнд 1,047.0 сая, иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 184.2 сая, нийт 3,149.7 сая төгрөгийг төвлөрсөн арга хэмжээнд төсвөөс зарцуулсан байна.

2013 онд Хөдөлмөрийн сайдын төвлөрсөн арга хэмжээний зардалд 4,101.7 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 3,149.7 сая төгрөгийг зарцуулж, тусгайлан санхүүгийн тайлан бэлтгэхгүйгээр дараах зардлуудыг төсвийн зардлаар тайлагнасан байна. Тухайлбал:

- “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд Завхан аймагт 250.0 сая, Увс аймагт 100.0 сая, Сүхбаатар аймагт 150.0 сая, Дундговь аймагт 100.0 сая төгрөгийг тус тус хөдөө орон нутагт шинэ ажлын байр бий болгох туршилтын төсөл хөтөлбөрүүд нэртэйгээр санхүүжүүлж, дэмжлэг үзүүлсэн байна.

- Залуучуудын хөдөлмөрийн биржтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, “Ажлын гараа”, “Сумын залуус” нэртэй төсөл хөтөлбөрүүдийг нийт 520.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.
- Хөдөлмөрийн хэлтсүүдэд Ординат ХХК-иас “Винница” санхүүгийн програмыг 32 байгууллагад 24.9 сая төгрөгөөр авч өгсөн ба харьяа байгууллагуудын 125 хүнийг УСНББОУС, татварын боловсрол, НББ-ийн бодлого боловсруулах чиглэлээр Монголын Нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнтэй хамтран 25.0 сая төгрөгөөр мэргэшүүлэх сургалтад хамруулсан, 17.2 сая төгрөгөөр материаллаг баазыг сайжруулах зорилгоор хөрөнгө бэлтгэсэн байна.

Төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэн хөрөнгийн үр дүнг тооцож, төвлөрсөн арга хэмжээний зардлын санхүүжилтийн тайланг тусад нь бэлтгэж, нэгтгэлд хамруулах шаардлагатай байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлэн захирагчийн 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газар аудит хийсэн ба уг аудитаар 4 зөвлөмж өгөгдсөнийг 80 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын санал дүгнэлт

Бид Хөдөлмөрийн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-86

ХӨДӨЛМӨРИЙН САЙД
Я.САНЖМЯТАВ ТАНАА

2014.04.25 № 698
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөрийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Хөдөлмөрийн яамны удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөрийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070481

**ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН
ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1

Асуудал 1

Зориулалт бус зарцуулалтын талаар

Асуудал 2

Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Асуудал 3

Төсвийн төлөвлөлтийн талаар

Асуудал 4

Санхүүгийн тайлагналын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Хөдөлмөрийн сайдын төсвийн багцын нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан Хөдөлмөрийн яамны ССБТГ-ын дарга С.Наранцогт, Ерөнхий нягтлан бодогч Ц.Эрдэнэтөгс болон бусад санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

Асуудал 1 Зориулалт бус зарцуулалтын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
<p>ҮАГ-ын ажиглалт</p> <p>УИХ-аар батлагдаагүй боловч 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хуралдаанаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн 2013 онд батлагдсан төсвөөс шинээр байгуулагдаж буй Хөдөлмөрийн хэлтсүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, ажиллах нөхцөл байдлыг бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын шинж чанартай, тоног төхөөрөмж 850.3 сая, тавилга эд хогшил 735.6 сая, автомашин 1,428.0 сая нийт 3,013.9 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулахаар шийдвэрлэж, Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/23 дугаар тушаалаар баталсан ба зарцуулалтыг ХЭДС-гийн санхүүжилтээр орон нутаг, дүүргүүдэд хуваарилсан байна.</p>	<p>ҮАГ-ын зөвлөмж</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйл 23.3-д: “ХЭДС-гийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэснийг мөрдөж ажиллах,</p> <p>Хөрөнгө оруулалтын шинж чанартай хөрөнгө /авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил/-ыг санхүүжүүлэх эх үүсврийг УИХ-аар батлуулан зарцуулж байх,</p>
<p>Эрсдэл</p> <p>Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх;</p>	<p>Үйлчлүүлэгчийн хариу</p> <p>Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулсан болно.</p>

ҮАГ-ын ажиглалт

ХЭДС-гаас хөдөлмөрийн хэлтсүүдэд бэлтгэсэн нийт 3,013.9 сая төгрөгийн хөрөнгийн 1,428.0 сая төгрөгийн автомашиныг худалдан авах ажиллагааг орон нутгийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан бол 1,585.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгын худалдан авалтын үйл ажиллагаа, тендер хаана зохион байгуулагдсан нь тодорхойгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Хөдөлмөрийн хэлтсүүдийн худалдан авсан автомашины үнийн судалгааг харьцуулахад 2006 оны Лексус 470 автомашиныг Архангай аймаг 50.0 сая, Баян-Өлгий аймаг 67.4 сая, 2006-2007 оны Стар икс автомашиныг Баянхонгор, Булган, Дархан-Уул, Орхон аймгууд 16.0-23.0 сая, 1997 оны Ланд крузер 80 автомашиныг Увс аймаг 39.9 сая, Ховд аймаг 24.0 сая, 2005 оны Ланд крузер 105 автомашиныг Хэнтий аймаг 68.0 сая, 2010 оны оны Ланд крузер 200 автомашиныг Завхан аймаг 68.0 сая төгрөгөөр харилцан адилгүй үнээр худалдан авсан байна.

Эрсдэл

Бүртгэлээр тавих хяналт, хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

ТЕЗ-ийн зүгээс тавих дотоод хяналтыг сайжруулж, худалдан авалтыг холбогдох хууль журамд нийцүүлэн хийх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн гүйцэтгэлээр ажилгүйдлийн даатгал, бичиг хэрэг, биеийн тамирын уралдаан тэмцээн, тавилга, урсгал засвар, төлбөр хураамж болон бусад зардал, банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж, амь даатгал зэрэг зардлууд 1.0-163.9 сая төгрөгөөр батлагдсан төсөвт зардлаас хэтэрсэн байна.

2013 онд нийт төсвийн гүйцэтгэлээр цалин хөлс, НДШ-ийн зардал 1,655.5 сая, урсгал үйл ажиллагааны зардал 1,925.2 сая, зардлын зүйл тус бүрээр хянах зардал 33,056.9 сая, нийт 36,637.6 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6.4.1-д: “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг мөрдөж ажиллах

Эрсдэл

Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

ҮАГ-ын зөвлөмж

2013 онд Хөдөлмөрийн сайдын төвлөрсөн арга хэмжээний зардалд 4,252.8 сая төгрөг төсөвлөснөөс 3,149.7 сая төгрөгийг зарцуулж, тусгайлан санхүүгийн тайлан бэлтгэхгүйгээр дараах зардлуудыг төсвийн зардлаар тайлагнасан байна. Тухайлбал:

Төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэн хөрөнгийн үр дүнг тооцдог байх, төвлөрсөн арга хэмжээний зардлын санхүүжилтийн тайланг тусад нь бэлтгэж, нэгтгэлд оруулах;

- “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд Завхан аймагт 250.0 сая, Увс аймагт 100.0 сая, Сүхбаатар аймагт 150.0 сая, Дундговь аймагт 100.0 сая төгрөгийг тус тус хөдөө орон нутагт шинэ ажлын байр бий болгох туршилтын төсөл хөтөлбөрүүд нэртэйгээр санхүүжүүлж, дэмжлэг үзүүлсэн байна.
- Залуучуудын хөдөлмөрийн биржтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, “Ажлын гараа”, “Сумын залуус” нэртэй төсөл хөтөлбөрүүдийг нийт 520.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.
- Хөдөлмөрийн хэлтсүүдэд Ординат ХХК-иас “Винница” санхүүгийн програмыг 32 байгууллагад 24.9 сая төгрөгөөр авч өгсөн ба харьяа байгууллагуудын 125 хүнийг УСНББОУС, татварын боловсрол, НББ-ийн бодлого боловсруулах чиглэлээр Монголын Нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнтэй хамтран 25.0 сая төгрөгөөр мэргэшүүлэх сургалтад хамруулсан, 17.2 сая төгрөгөөр материаллаг баазыг сайжруулах зорилгоор хөрөнгө бэлтгэсэн байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлагнал УСНББОУС болон холбогдох заавар, журмын дагуу хийгдээгүй байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулсан болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
Хөрөнгө	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,618,392,277.53	67,669,990,178.40
Авлага	455,410,652,559.12	425,051,193,671.79
Урьдчилгаа тооцоо	3,574,298,845.00	24,640,531.65
Бараа материал	8,683,732,352.95	8,968,299,558.79
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн	474,287,076,034.60	501,714,123,940.63
Эргэлтийн бус хөрөнгө		
Биет бус хөрөнгө	87,025,457,873.82	106,061,108,897.87
Биет бус хөрөнгө	285,825,243.09	1,610,471,383.58
Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн	87,311,283,116.91	107,671,580,281.45
Хөрөнгийн нийт дүн	561,598,359,151.51	609,385,704,222.08
Өр төлбөр		-
Өглөг	301,120,484,347.31	326,755,510,048.90
Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн	301,120,484,347.31	326,755,510,048.90
Өглөг	13,735,834.87	13,735,834.87
Урт хугацаат өр төлбөрийн нийт дүн	13,735,834.87	13,735,834.87
Өр төлбөрийн нийт дүн	301,134,220,182.18	326,769,245,883.77
Цэвэр хөрөнгө/өмч		
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	70,944,573,020.69	67,596,307,585.29
Хуримтлагдсан үр дүн	158,978,133,955.73	184,595,558,407.52
Өмнөх үеийн үр дүн	158,978,133,955.73	158,594,208,474.54
Тайлант үеийн үр дүн		26,001,349,932.98
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	30,541,431,992.91	30,424,592,345.50
Цэвэр хөрөнгө/өмчийн нийт дүн	260,464,138,969.33	282,616,458,338.31
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн нийт дүн	561,598,359,151.51	609,385,704,222.08

СТ-2А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
Тусламж, санхүүжилтийн орлого	79,957,907,977.18	109,775,193,116.78
Олон улсын байгууллагын тусламж	3,860,000,368.00	-
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	76,097,907,609.18	109,775,193,116.78
Улсын төвлөрсөн төсвөөс	68,792,307,646.88	109,580,038,022.78
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	56,193,785,953.88	75,296,740,488.00
Хөрөнгийн	12,598,521,693.00	10,793,905,440.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	11,426,552,000.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө	-	1,515,994,144.90
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	-	9,300,845,332.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,246,000,617.88
Төсөвт байгууллагаас	1,820,400,000.00	195,155,094.00
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	5,485,199,962.30	-
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	90,948,825,286.47	91,297,645,043.64
Үйл ажиллагааны орлогын дүн	170,906,733,263.65	201,072,838,160.42
Ажиллагсдын зардал	24,243,095,987.60	35,851,909,650.81
Урсгал зардал	34,569,550,691.97	51,384,719,957.69
Хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгийн ашиглалт	13,912,057,745.00	11,142,463,809.25
Татаас	24,000,000,000.00	290,000,000.00
Тусламж, шилжүүлэг	31,753,236,045.27	29,076,520,943.27
Нийгмийн хамгааллын зардал	33,080,900,564.38	46,542,402,789.75
Бусад зардал	169,112,773.56	491,152,451.47
Үйл ажиллагааны зардлын дүн	161,727,953,807.78	174,779,169,602.24
Үйл ажиллагааны үр дүн	9,178,779,455.87	26,293,668,558.18
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	647,329.54	-
Үйл ажиллагааны бус орлогын дүн	647,329.54	-
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	19,750,933.86	277,022,927.37
Гадаад валютын ханшийн зөрүү	-	1,965,191.44
Үнэ төлбөргүй гарсан зардал	-	13,330,506.39
Үйл ажиллагааны бус зардлын дүн	19,750,933.86	292,318,625.20
Үйл ажиллагааны нийт үр дүн	9,159,675,851.55	26,001,349,932.98

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
Тусламж, санхүүжилтийн орлого	93,236,500,872.18	206,704,428,828.95
Олон улсын байгууллагын тусламж	9,010,993,263.00	-
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	84,225,507,609.18	206,704,428,828.95
Улсын төвлөрсөн төсвөөс	68,792,307,646.88	206,509,273,734.95
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	56,193,785,953.88	75,296,740,488.00
Хөрөнгийн	12,598,521,693.00	10,793,905,440.00
Тусламжийн сангаас санхүүжсэн	-	34,421,100,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	11,426,552,000.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	-	1,515,994,144.90
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	-	9,300,845,332.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,358,437,199.43
Төсвийн урамшуулал	-	62,395,699,130.62
Төсөвт байгууллагаас	9,948,000,000.00	195,155,094.00
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	5,485,199,962.30	-
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	178,995,736,329.86	136,621,238,018.19
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	272,232,237,202.04	343,325,666,847.14
Ажиллагсдын зардал	24,108,763,868.08	35,915,167,386.14
Урсгал зардал	36,207,446,422.29	42,718,886,874.24
Татаас	24,000,000,000.00	6,663,246,840.53
Тусламж, шилжүүлэг	93,945,859,075.89	38,776,693,054.94
Нийгмийн хамгааллын зардал	36,547,565,562.75	43,315,155,679.79
Үйл ажиллагааны мөнгөн зардлын дүн	214,809,634,929.01	167,389,149,835.64
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	57,422,602,273.03	175,936,517,011.50
Зээлийн орлого	13,670,067,076.00	-
Эргэн төлөлт	13,670,067,076.00	-
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	13,670,067,076.00	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,954,819,306.50	1,862,538,483.29
Хөрөнгийн бусад зардал	13,912,057,765.00	11,142,463,809.25
Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	15,866,877,071.50	13,005,002,292.54
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(2,196,809,995.50)	(13,005,002,292.54)
Эргэж төлөгдөх цэвэр зээл	(48,607,400,000.00)	(101,877,951,626.65)
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	48,607,400,000.00	101,877,951,626.65
Гадаад валютын ханшийн зөрүү	-	(1,965,191.44)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(48,607,400,000.00)	(101,879,916,818.09)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	6,618,392,277.53	61,051,597,900.87
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,618,392,277.53
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,618,392,277.53	67,669,990,178.40

СТ-4А

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
2012 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	149,818,458,104.18	149,818,458,104.18
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	149,818,458,104.18	149,818,458,104.18
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт	-	30,541,431,992.91	-	30,541,431,992.91
үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	70,944,573,020.69	-	-	70,944,573,020.69
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	9,159,675,851.55	9,159,675,851.55
2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	70,944,573,020.69	30,541,431,992.91	158,978,133,955.73	260,464,138,969.33
2013 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	70,944,573,020.69	30,541,431,992.91	158,978,133,955.73	260,464,138,969.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(383,925,481.19)	(383,925,481.19)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,944,573,020.69	30,541,431,992.91	158,594,208,474.54	260,080,213,488.14
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт бууралт	-	(116,839,647.41)	-	(116,839,647.41)
Үндсэн хөрөнгийн есөлт бууралт	(3,348,265,435.40)	-	-	(3,348,265,435.40)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	26,001,349,932.98	26,001,349,932.98
2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	67,596,307,585.29	30,424,592,345.50	184,595,558,407.52	282,616,458,338.31

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх

/төгрөгөөр/

ЗАРДЛЫН НЭР, ТӨРӨЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		6,618,392,277.53	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	235,156,166,300.00	198,518,593,986.78	(36,637,572,313.22)
Нийт зарлагын дүн	156,056,166,300.00	131,061,742,360.13	(24,994,423,939.87)
Урсгал зардлын дүн	142,609,466,300.00	122,712,412,609.13	(19,897,053,690.87)
Бараа, үйлчилгээний зардал	67,804,331,400.00	59,423,929,076.44	(8,380,402,323.56)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,401,337,000.00	29,995,720,119.12	(1,405,616,880.88)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,516,888,500.00	3,260,084,214.02	(256,804,285.98)
Бараа үйлчилгээний урсгал зардал	32,886,105,900.00	26,168,124,743.30	(6,717,981,156.70)
Гэрэл цахилгаан	931,293,300.00	755,326,967.92	(175,966,332.08)
Түлш, халаалт	4,636,005,300.00	4,233,513,570.83	(402,491,729.17)
Цэвэр, бохир ус	675,487,200	471,606,031	(203,881,169.38)
Бичиг хэрэг	348,316,400	371,118,023	22,801,622.64
Тээвэр (шатахуун)	476,596,400	448,035,180	(28,561,219.80)
Шуудан холбоо	540,392,000.00	437,923,158.37	(102,468,841.63)
Дотоод албан томилолт	575,185,700.00	550,242,853.87	(24,942,846.13)
Гадаад томилолт /арга хэмжээ/	146,422,200.00	129,303,613.18	(17,118,586.82)
Ном хэвлэл авах	150,460,800.00	140,593,192.64	(9,867,607.36)
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	4,187,640.00	2,187,640.00
Багаж хэрэгсэл	420,086,500.00	229,166,530.16	(190,919,969.84)
Тавилга	291,456,100.00	320,599,356.49	29,143,256.49
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	72,144,600.00	71,398,498.00	(746,102.00)
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	311,231,500.00	291,670,707.19	(19,560,792.81)
Програм хангамж	474,024,300.00	77,449,490.00	(396,574,810.00)
Нормын хувцас зөөлөн эдлэл	253,280,200.00	224,417,390.19	(28,862,809.81)
Хоол	3,016,092,600.00	2,412,367,303.55	(603,725,296.45)
Эм	207,515,900.00	197,055,551.00	(10,460,349.00)
Урсгал засвар	2,032,685,200.00	2,008,756,613.37	(23,928,586.63)
Төлбөр хураамж болон бусад зардал	235,888,500.00	399,597,005.50	163,708,505.50
Гадаад зочны зардал	21,683,700.00	20,234,804.00	(1,448,896.00)
Биеийн тамирын уралдаан тэмцээн	134,808,200.00	137,850,422.00	3,042,222.00
Холбооны суваг ашигласны хөлс	2,271,600.00	2,271,600.00	-
Байрны түрээсийн зардал	509,554,800.00	463,787,612.74	(45,767,187.26)
Төвлөрсөн арга хэмжээ	4,252,809,900.00	3,214,126,719.66	(1,038,683,180.34)
Баяр наадмын зардал	14,650,000.00	10,716,260.00	(3,933,740.00)
Маягт хэвлэх зардал	1,260,000.00	-	(1,260,000.00)
Давтан сургалтын зардал	40,711,500.00	27,037,840.00	(13,673,660.00)
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага, сургуулилт	10,905,592,100.00	7,719,570,645.32	(3,186,021,454.68)
Төрийн албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх зардал	158,045,100.00	99,984,373.00	(58,060,727.00)
Гадаад сургалт, семинарт оролцох зардал	67,000,000.00	-	(67,000,000.00)
Сургалт, семинар зохион байгуулах зардал	397,534,300.00	252,434,314.93	(145,099,985.07)
Эрдэм, шинжилгээ, судалгааны ажлын хөлс	25,000,000.00	618,750.00	(24,381,250.00)
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	224,250,000.00	210,366,520.00	(13,883,480.00)
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (гадаад)	23,570,000.00	15,018,395.00	(8,551,605.00)
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,686,900.00	4,899,763.32	2,212,863.32
Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (дотоод)	48,156,000.00	37,773,706.00	(10,382,294.00)
Эд хөрөнгийн даатгал	21,929,400.00	17,339,294.00	(4,590,106.00)
Тээврийн хэрэгслийн даатгал	20,713,000.00	15,944,546.12	(4,768,453.88)
Харуул, хамгаалалтын хөлс	37,715,600.00	27,092,757.84	(10,622,842.16)
Тээврийн хэрэгслийн оношилгоо	325,000.00	-	(325,000.00)
Улсын мэдээллийн маягт бэлтгэх	14,656,000.00	11,145,300.00	(3,510,700.00)
Мэдээлэл сурталчилгааны зардал	147,228,100.00	94,040,125.40	(53,187,974.60)
Товхимол, тараах материал	12,500,000.00	9,855,096.00	(2,644,904.00)
Хог хаягдал устгах, цэвэрлэх	4,890,000.00	1,687,222.25	(3,202,777.75)

Татаас ба урсгал шилжүүлэг	74,805,134,900.00	63,288,483,532.69	(11,516,651,367.31)
Тухайн шатны төсөвт төвлөрүүлэх орлого	24,000,000,000.00	24,000,000,000.00	-
ЭХМТ комисс МӨС -ын төвийн зардал	15,609,000.00	12,867,408.00	(2,741,592.00)
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	118,945,000.00	71,847,199.10	(47,097,800.90)
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	823,397,400.00	720,876,258.00	(102,521,142.00)
Ээлжийн амралтаар нутаг явах унааны зардал	12,982,000.00	541,800.00	(12,440,200.00)
Нэг удаагийн буцалтгүй тусламж	273,462,700.00	232,768,702.00	(40,693,998.00)
Эмчилгээний төлбөр	6,533,200.00	2,458,716.40	(4,074,483.60)
Шагнал, урамшил	55,865,700.00	33,074,678.80	(22,791,021.20)
Хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох тэтгэмж	457,959,200.00	439,782,771.00	(18,176,429.00)
Хуульд заасан үндэслэлээр албан хаагчдад олгох нөхөн олговор	848,952,300.00	734,112,889.00	(114,839,411.00)
Хөдөлмөр, ажил эрхлэлт, ЖДҮ дэмжих чиглэлээр өгөх тусламж, дэмжлэг, сургалт	33,400,000,000.00	25,490,553,669.63	(7,909,446,330.37)
Суралцагсадад олгох амьжиргааны тэтгэлэг	14,740,695,700.00	11,502,232,929.85	(3,238,462,770.15)
Амь даатгал	8,496,000.00	9,496,373.91	1,000,373.91
Газрын төлбөр	10,668,800.00	7,455,147.00	(3,213,653.00)
Тээврийн хэрэгслийн татвар	18,567,900.00	17,945,340.00	(622,560.00)
Олон улсын байгууллагын гишүүний татвар	13,000,000.00	12,469,650.00	(530,350.00)
Хөрөнгийн зардал	13,446,700,000.00	8,349,329,751.00	(5,097,370,249.00)
Хөрөнгө оруулалт :Төсвийн хөрөнгөөр санхүүжих	8,612,500,000.00	4,640,267,137.00	(3,972,232,863.00)
Тоног төхөөрөмж : Төсвийн хөрөнгөөр санхүүжих	3,613,800,000.00	2,580,616,705.00	(1,033,183,295.00)
Төсөвт газрын их засвар	1,220,400,000.00	1,128,445,909.00	(91,954,091.00)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	79,100,000,000.00	67,456,851,626.65	(11,643,148,373.35)
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	79,100,000,000.00	67,456,851,626.65	(11,643,148,373.35)
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	235,156,166,300.00	206,410,495,315.92	(28,745,670,984.08)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	138,795,133,400.00	124,470,941,206.18	(14,324,192,193.82)
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,105,595,700.00	3,166,006,317.01	2,060,410,617.01
Төсвөөс санхүүжих	95,255,437,200.00	78,773,547,792.73	(16,481,889,407.27)
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	67,669,990,178.40	
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		53,159,696,571.73	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	118.00	106.00	
АЖИЛЛАГСАД БҮГД	4,200.00	4,058.00	
Удирдах ажилтан	124.00	122.00	
Гүйцэтгэх ажилтан	2,506.00	2,583.00	
Үйлчлэх ажилтан	1,561.00	1,347.00	
Гэрээт ажилтан	9.00	6.00	
СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/	47,879.00	38,316.00	